



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Б.БААТАРЗОРИГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [statereathural@parliament.mn](mailto:statereathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2021.12.17 № 47.

Асуулга тавих тухай

Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Төрийн албаны хуулийг шинэчлэн баталсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-д “Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж, 4.2.2-т “Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.” гэж, 4.2.5-д “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомжийн хэрэгжилт нэг мөр хангагдахгүй байх, батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хэрэгждэггүй, түүнчлэн төрийн албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ зөвхөн хуульд захирагдан ажиллах зарчмыг баримталдаггүй, хясан боогдуулах замаар шан харамж авдаг гэсэн хардлага нь иргэдийн төрд итгэх итгэлийг сулруулах үндсэн суурь шалтгаан болоод байна.

Төрийн албан хаагч Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд орших эрхэм зорилгоо сахин биелүүлэх үүрэгтэй.

Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох нь Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийн асуудал.

2021000213

Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн дарга Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Төрийн захиргааны тэргүүн түшмэлийн болон түүнтэй адилтгах албан тушаалын сонгон шалгаруулалтын нээлттэй, ил тод байдал болон 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дэлгэрэнгүй мэдээлэл;

2.2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлагын тайлан;

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар;


4.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиас бусад хуулийн дагуу олон нийтийг биечлэн хамруулах арга хэмжээг зохион байгуулах, албан тушаалтныг сонгон шалгаруулахаар хуульчилсан зохицуулалтыг энэ хуулийн үйлчлэл зогссон өдрөөс эхлэн тухайн хуульд заасан хугацааг баримтлан хэрэгжүүлнэ.” гэж заасныг хэрхэн ойлгож, хэрэгжүүлж байгаа талаар;

5.2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, түүнтэй адилтгах байгууллагын тэргүүн түшмэлийн орон тоонд томилсон шийдвэр, байгууллагын нэр, албан тушаалтны нэр, үндэслэлийн талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ

2021000213